

Улаанбаатар хотын зочлох үйлчилгээний салбарын үүсэл хөгжил

Найман овогт Баделгажын Ербахыт

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
мэргэжилтэн, магистрант

Erbahit_10@yahoo.com

Түлхүүр үг: зочлох үйлчилгээ, монгол айл гэрийн зочломтгой ёс, хоолны газар, зочид буудал, амралтын газар,

Abstract: The service sector was founded and developed in 1639 in Ulaanbaatar, and the time divided into four phases of development. The first hospitality service was founded at the beginning of 17th century by serving Bogd Khaan's honorary guests. Nowadays the service sector becoming the urgent sector of Ulaanbaatar city and the main sector of service sector is hospitality.

Нийслэл Улаанбаатар хотын зочлох үйлчилгээний салбар 375 жилийн түүхтэй бөгөөд зочлох үйлчилгээний салбарын үүсэл, хөгжил Улаанбаатар хотын үүсэл хөгжилтэй салшгүй холбоотой. Зочлох үйлчилгээний салбар 1639 онд Өргөөтэй хамт үүсэж бий болсон бөгөөд энэ нь дараах баримтаар батлагдана. 1639 онд 5 настай Занабазарыг Монголын шарын шашны тэргүүнд өргөмжилж өргөө гэр шар бүсийн орд барьж өгч, халхын ноёд өөр өөрийн албат нараас түүнд үйлчлэх албатуудыг шавь болгон таслан өгчээ. Энэ тухай “Эрдэнийн эрих”-д “таван насны шарагчин туулай жил халхын газраа халхчууд бүгдээр Цагаан нуурын газар ширээнд анх суулгаж, гэгээн хэмээх цол, шар бүсийн хот өргөж, эрхэмлэн тахивай” гэжээ. Мөн Монголын түүхийн өөр нэг сурвалж “Богд Жавзундамбын анхан төрлийн нэр оршибой” хэмээх бүтээлд энэ талаар “Эрдэнийн эрих”-д бичсэнийг ерөнхийдөө давтаж Монголын ноёд “Энэ жил дор ... олон газраас өвөр, өврийн тайж албатаас гаргаж, тусгай лам хар шавийг байгуулж өгөв”¹ гэж нэмж дурьджээ.

Доктор С.Идшинноров Өргөөний тухай “Гэгээний өргөө нь эхэн үедээ тухайн үеийн Монголын бусад ноёдын орд өргөөнөөс онцын ялгагдах зүйлгүй байв. Гэгээний өөрийн болон түүнд үйлчлэгч хүмүүсийн суух цөөн тооны эсгий гэр, бурхан шүтээний гэр дуганаас бүрдсэн, нүүдлийн амьдралд зохицсон, сүм хийдийн шинжтэй гэхээсээ илүү ордны шинжтэй байжээ”² гэж бичсэн байна. Эндээс Өргөө анх байгуулахдаа Богд Гэгээнд үйлчлэх тусгай үйлчилгээний албаттай байсныг харж болхоор байна. Учир нь түүхийн аль ч үед нэр нөлөөтэй хүмүүс өөрт нь үйлчлэх үйлчлэгч хүмүүсийг хажуудаа байлгадаг тухай баримт их байдаг. Үүний адил Богд Гэгээнтэнд үйлчлэх үйлчлэгч хүмүүс байсан байна. Чухам энэ үйлчилгээний албатуудыг зочлох үйлчилгээний салбарын анхны суурь, анхны үйлчилгээний байгууллага нь гэж ойлгож болхоор байна. Үйлчлэгч нар Богдын өргөөнд үйлчлэхээс гадна хүндэт зочид төлөөлөгчид мөн үйлчилдэг байжээ. Богдын Өргөөнд хүндэт зочид үйлчлэх тусгай гэр байсан бөгөөд үүнийг зочлох үйлчилгээний салбарын анхны байгууллага гэж үзэж болхоор байна. Энэ тухай эрдэмтэн С.Идшинноров “Улаанбаатар хотын хураангуй түүх” номонд “Цаашдаа Гэгээний нэр хүнд өсч, Монголын нийгмийн амьдралд үзүүлэх нөлөө нь нэмэгдэхийн хирээр Өргөө өргөжин тэлж, ач холбогдол, нэр хүнд нь өссөөр байжээ. Энэ бол Гэгээний өргөө Монголын бусад ноёдын орд өргөөг бодоход бас өвөрмөц онцлогтой байсантай холбоотой юм. Өргөө нь тус орны нийгмийн янз бүрийн хүчний анхаарлыг бусад ноёдын өргөөнөөс хавьгүй илүүгээр өөртөө татаж байлаа. Өргөөнд хол ойрын мөргөлчид, хутагт болон тэнд байнга суугчдын хүнс хэрэглэлийг нийлүүлэх шавь хамжлагын хүмүүст тогтмол ирдэг байснаас гадна Халхын ноёд, лам нар Богдод бат оршил өргөхөөр олон дагуул сэлтийн хамт үе үе цуглан,

¹ Galdan, “ERDENI-YIN KEMEKÜ TEÜKE BOLAI”, 1841, translation and commentary by J.Gerelbadrakh.

² С.Идшинноров, “Улаанбаатар хотын түүхийн хураангуй,” УБ, 1994 он. Хууд-7

түүний далимаар чуулган хийж, найр наадам хийдэг байжээ”³ гэж тэмдэглэсэн байна. Дээрх ишлэлээс Богд Гэгээнтэнд бараалхахаар хол ойрын янз бүрийн хүндтэй зочид төлөөлөгчид ирдэг байсныг баталж байна. Эдгээр зочид төлөөлөгчид тусгай гэрт байрлаж амарч тухладаг байсан ба Богдын үйлчлээний албат зочдод мөн үйлчилдэг байсан гэж дүгнэж болхоор байна.

Улаанбаатар хотод зочлох үйлчилгээний салбарын хөгжлийг гурван үе шатанд хуваан авч үзэж болох юм. Монголын зочломтгой ёсноос үүдэн бий болсон Улаанбаатар хотын зочлох үйлчилгээний салбар дөрвөн үе шатыг дамжин хөгжиж өдгөө олон улсын чанарт нийцсэн үйлчилгээтэй Улаанбаатар хотын томоохон салбар болтлоо хөгжиж чадсан байна.

МОНГОЛ АЙЛ ГЭРИЙН ЗОЧЛОМТГОЙ ЁСОНД ТУЛГУУРЛАСАН ЗОЧЛОХ ҮЙЛЧИЛГЭЭ БИЙ БОЛСОН ҮЕ. /1639-1860 ОН/

Өргөө анх үүссэн үед Богд Гэгээнтэнд баралхахаар ирсэн зочид тусгай гэрт байрлаж амардаг байсан ба Богдын хүндэт зочдод тусгайлан үйлчилдэг албатууд байсан тухай дээр дурьдсан. Хэдийгээр зочлох үйлчилгээ Монгол айл гэрийн зочломтгой ёсноос үүдэлтэй бий болсон ч Монгол айл гэрийн зочломтгой ёсноос салгаж ойлгох хэрэгтэй. Учир нь Монголчуудын зочлох ёсонд аливаа зочдыг гэртээ дайлж, цайлж тухайн гэрийн эзэгтэй үйлчилдэг байсан. Харин Өргөөний зочдод үйлчлэх тусгай гэрүүд нь зочид, төлөөлөгчид тусгайлан байрлаж амарч тухлах зориулалттай гэрүүд байсан юм. Мөн үйлчлэгч нар өөр өөрсдийн гэрт байрлаж зөвхөн шаардлагатай үед үйлчилгээнд гардаг байсан байна. Дээрх хоёр ялгаагаараа Монгол айл гэрийн зочломтгой ёсноос өөр бөгөөд энэ гэрүүдийг анхны үйлчилгээний байгууллагууд гэж ойлгож болно. Харин Богдын өргөөнд ийм хэдэн гэр байсан талаар, тэнд хичнээн үйлчилгээний албат байсан талаар мэдээлэл хомс байна. Богдын өргөөнд 1-2 үйлчилгээний гэрүүд байсан бололтой. Мөн Өргөө өргөжин тэлж хүн ам өссөнтэй холбоотой Хүрээний нэр хүндтэй зарим ноёдууд зочдод зориулсан тусгай гэртэй байжээ.

Өргөө нүүдэллэж явахдаа эдгээр гэрүүдийг хамт нүүлгэж авч явдаг байсан бөгөөд 1860 он хүртэл нүүдэлчин хэлбэртэй байсан бөгөөд энэ үеийг өөрөөр “Нүүдэлчин соёлтой зочлох үйлчилгээний салбарын үе” гэж нэрлэж болно. Гэхдээ ийм гэрүүд Өргөөнд цөөхөн байсан бөгөөд ихэнх нь Богдын хүндэт зочдод үйлчлэх үүрэгтэй байсан байна. Их хүрээ 1778 онд Хан уулын ар хормой, Хатан туулын хөвөөнд ирж суурьшсаны дараа хот болон хөгжиж эхэлсэн ч дараагийн зуун жилд ийм гэрүүд зочдод үйлчилсээр байсан байна. Эрдэнийн эрхд “Тэнгэр тэтгэсэний 49 дүгээр он буюу 1784 оны 11 дүгээр сард бүгд зургаан өргөө модон гэр үйлдэж, тойрон модон хашаа байгуулж, орос элч нарыг сахиулья”⁴ гэж дурьдсанаас үзвэл зочдод үйлчилдэг гэрүүд 18-р зууны сүүл хүртэл байсан байна. Гэхдээ хот болон өргөжсөнөөс хойш гэрүүдийн тоо болон үйлчилгээний албатуудын тоо нэмэгдсэн байна.

ЗОЧЛОХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙН САЛБАР СУУРИН ХЭЛБЭРТ ШИЛЖСЭН ҮЕ /1860-1926/

1860 он хүртэл Их Хүрээнд зочдод тусгайлан үйлчилдэг гэрүүдээс өөр зочлох үйлчилгээний байгууллагууд байсангүй. Эрдэмтэн Дугарсүрэн “Улаанбаатар хотын түүхээс” номонд “Хүрээний зах дээр хоол унд бэлтгэж худалдах тусгай газар 1878 он хүртэл байсангүй. Харин Хүрээнд байсан манж, хятад цэргийн хүмүүс зах дээр ил гар түлж, заримдаа салхий нь эсгий халхавчаар хаан мах шарж, хуушуур хийж худалддаг байжээ. Сүүлдээ монгол эмэгтэйчүүд ийм худалдааг нэлээд хийх болжээ. Хүрээнд зах зээлийн худалдаа өргөжсөнөөс үндэслэн анх 1878 онд зах дээр хоол цайны газар тусгай байртай байгуулагдаж, тэнд хүмүүс бэлэн хоол, цай, архи авч хэрэглэх, заримдаа хөдөөний хүмүүс тэнд буух зэргээр эхэлжээ”⁵ дурьдсан байдаг. Эндээс анхны гуанз буюу хоолны үйлчилгээний салбарын үүсэл тавигдсан гэж болхоор байна. 1855 онд Их Хүрээ Сэлбийн хөндийд сүүлчийн удаа нүүж бууснаас хойш тавиад жилийн дараа Их Хүрээнд зүүн хүрээ, Гандан, Баруун дамнуурчин, зүүн дамнуурчин, Маймаа хот, Хүрээний болон Хорооны харчууд, Консул сайдын яам, Дамбадаржаа зэрэг олон хэсгүүд бий болжээ. Эдгээрээс Маймаа хот, Зүүн дамнуурчин, Баруун дамнуурчинд ихэвчлэн худалдаачин хятад ирдэг суурьшдаг байсан бөгөөд 19-р зууны хоёр дугаар хагаст хятад дэн буудлууд байгуулагдаж эхэлжээ. Анх байшингийнхаа нэг өрөөнд зочин буюу жинчин хүмүүсийг байлгадаг байсан бол хожим тусгай байшин барьж тэндээ хүмүүсийг байлгаж, хоол ундаар үйлчилдэг болжээ. Оросын эрдэмтэн

³-С.Идшинноров, “Улаанбаатар хотын түүхийн хураангуй,” УБ, 1994 он. Хууд-7

⁴ - Galdan, “ERDENI-YIN KEMEKÜ TEÜKE BOLAI”, 1841 year, translation and commentary by J.Gerelbadrakh.

⁵ - Л.Дүгэрсүрэн “Улаанбаатар хотын түүхээс”, УБ, 1999 он. Хууд-35

Позднеевын бичсэнээр 1870-аад оны үед зөвхөн Маймаа хотод 374 хашаа байсны дотор хятад дэлгүүр-12, архи боов хоолны газар-57, буудлын газар 2 байсан тухай бичсэн байдаг. Хүрээнд анхны дэн буудлууд 1960-аад оны үед нээгдэж байсан болов уу. Мөн Доктор О.Пүрэв 1915 онд Нийслэл Хүрээнд хаана хэдэн үйлдвэр үйлчилгээний газар байсан тухай бичсэн байдаг⁶. Уг бүтээлээс үзэхэд

- Баруун дамнуурчинд 217 үйлдвэр үйлчилгээний газар байснаас 1-р гудамжинд 2 хоолны газар / тус бүр 2 ажилтантай/, 6-р гудамжинд 2 хоолны газар, 7-р гудамжинд 2 хоолны газар, 8-р гудамжинд 1хоолны газар, 9-р гудамжинд 1 хоолчны хэсэг ба нийт 8 газар байсан байна.
- Зүүн өмнөд хэсэгт харчуудын хэсэгт амбан ханы хороонд 8 хүнтэй нэг, Дотоод яамны баруун хойно 1 хоолны газар, Цахар чулууны хашаанд нэг хоолны газар байсан ба Баруун өмнөд хороо буюу Харчуудын хэсэгт Түшээт ханы хороонд 14 хүнтэй нэг хоолчин хэсэг, шинэ захад хоолчин пүүсний нэг салбар 5 хүнтэй, хоолчин хэсэг нэг, махны захад 7 хүнтэй нэг хоолчин хэсэг, сайн ноёны хороонд нэг, нийтдээ 8 хоолны газар
- Маймаа хотод хоолчин пүүсний салбар 1, хоолчин хэсэг 4 байсан ба Нийслэл Хүрээнд нийт 13 хоолны газарт 60 орчим хүн ажиллаж байсан гэсэн судалгаа байдаг.

Гэхдээ уг бүтээлд хүрээний зөвхөн зарим хэсгийг аваад үзсэнийг бодвол энэ тоо бодит тоо биш юм. Гэхдээ уг тоог үндэслэн тухайн үед 30-40 хоолны газар байсан болов уу гэж тооцолж болхоор байна. Харин дэн буудлуудын хувьд 1915 онд зочид буулгах 3 ажилтантай дэн буудал нэг, луугаар буулгах дэн буудал /жинчин/ 11 нийт 33 хүнтэй байсан байна. Уг мэдээнд тулгуурлаж авч үзвэл Маймаа хотоос өөр Хүрээнд дэн буудал байгаагүй бололтой. Эдгээр үйлчилгээний газрууд хэдийгээр мэргэжлийн хувийн үйлдвэрүүд боловч ажлын арга нь бүдүүлэг бүр зарц боолын шинжтэй учир хавиа дөнгөж аргацаасан шинжтэй байсан тухай О.Пүрэв гуай дурьдсан байна. О.Сүхбаатарын Цайны замын тухай өгүүлэлдээ Хөлийн гол, Сонсголонгийн өөртөө, Тайны аманд жинчдэд үйлчилдэг буудал, хоолны газар байсан тухай дурьдсан байдаг⁷.

Эдгээрээс өөр мэдээ баримт байхгүй бодвол тухайн үедээ Хүрээнд хэдэн хоолны газар, цөөхөн дэн буудлаас өөр зочлох үйлчилгээний байгууллагууд байхгүй байсан бололтой.

Энэ үед Улаанбаатар хотын зочлох үйлчилгээний салбарын анхны нэгж зочдод үйлчлэх гэрүүдийн үүргийг 3-4 өрөөтэй суурин байшингууд гүйцэтгэж эхэлжээ. Мөн энэ үеэс зочлох үйлчилгээний хоолны үйлчилгээний салбар хөгжиж эхэлсэн байна. Энэ үеийн нэг онцлог нь хоолны газруудын ихэнх нь томоохон пүүсүүдийн эзэнд харьяалтай олон салбаруудаас бүрдэж байжээ. Өөрөөр хэлбэл өнөөгийн Улаанбаатар хотод байгаа сүлжээ хоолны газрууд, сүлжээ ресторануудын эхлэл 18-р зууны сүүлээс тавигджээ.

ОРЧИН ЦАГИЙН ЗОЧЛОХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРЫН ҮҮСЭЛ ТАВИГДСАН ҮЕ /1926-1991/

Улаанбаатар хотод орчин цагийн зочлох үйлчилгээний салбар 1926 оноос хөгжиж эхэлсэн бөгөөд үүнийг дараах баримтуудаар нотолж болно.

- 1925 онд Улаанбаатар хотын жинхэнэ захиргааг хотын ард олны оролцоотой сонгуулийн үндсэн дээр хөдөлмөрчдийн хурлаар байгуулав. Улсын хоёрдугаар их хурлаар дөчин есөн зүйлтэй “Улаанбаатар хотын захиргааны газрын дагаж явах дүрэм” 1925 оны 12 дугаар сарын 11-нд баталсан бөгөөд энэ дүрэмд хотын захиргаанаас эрхлэн гүйцэтгэх олон ажлууд дурдсаны нэг нь хоолны ба буудлын газруудыг байгуулах явдал байв.
- 1925 оноос Улаанбаатар хотын захиргаанаас тусгай комисс томилон Улаанбаатар хотын хогийг цэвэрлэх, мод тарих ажлыг эхлүүлж хотын өнгө төрхөнд онцгой анхаарч эхэлсэн байна. Уг комиссоос ард түмний оролцоотойгоор Улаанбаатар хотын ардын цэнгэлдэх хүрээлэн, Цагаан сүмийн орчимд мод тарьжээ. Дараа жил 1926 оноос Цагаан сүмийн өмнөх цэцэрлэгийн хүрээлэнд гуанз байгуулж, улмаар уг газрыг бүхэлд нь бусдад түрээслүүлэн олон нийтийг амарч цэнгэх ажлыг зохион байгуулж байжээ. Хотод гадна дотноос ирэгсдийг буудаллуулах дэн буудлыг хотын захиргааны харьяанд байгуулав.

⁶ -О.Пүрэв, “Монгол төрийн голомт”. УБ, 2004 он, (108-116 хууд)

⁷ О.Сүхбаатар. “Цайны замын суурь өртөөний байршил”, “Нүүдэлчдийн өв соёл”, УБ, 2012 он.

- 1926 онд Амгаланбаатар хотод хүн суух 28 тасалгаа, бараа агуулах 38 тасалгаа бүхий дэн буудлыг байгуулж “Улаанбаатар хотын 1-р дэн буудал” хэмээн нэрлэжээ[1.79]. Эдгээр хоолны газар, дэн буудлууд нь Улаанбаатар хотын анхны боловсон зочлох үйлчилгээний байгууллагууд юм.

1926 оноос эхэлж Хүрээний монгол, хятадын зан заншилд тулгуурласан зочлох үйлчилгээний салбар шинэ шатанд гарч орчин үеийн зочлох үйлчилгээний салбар болон хөгжиж эхэлсэн юм. 1927 оны 3-р сард 5-р хорооны 6-р гудамжинд буюу одоогийн Амгаланд байсан хуучин хятадын дэн буудлыг 9800 төгрөгөөр худалдан авч, хотын захиргааны 2-р дэн буудал болгожээ. 1928 оны 10-р сард Улаанбаатар хотын хурлын төлөөлөгчдийн 5 их хурал хуралдаж, хотын захиргааны илтгэлийг авч хэлэлцжээ. Уг илтгэлд хүрээний тухайн үеийн байдлыг илтгэн харуулсан чухал баримтууд дурьдсаны дотор үйлчилгээний байгууллагуудтай холбоотой дараах тоо баримтуудыг дурьдсан байна. Улаанбаатар хотын 2-р хороонд хоолны гуанз 9, 3 хороонд гуанз 13, 4-р хороонд 1, 6-р хороо буюу Амгаланбаатар хотод гуанз 3 байв⁸. Харин дэн буудал, бусад үйлчилгээний байгууллагын талаар ямар нэгэн тоо дурьдаагүй байна. Энэ нь Улаанбаатар хотын үйлчилгээний байгууллагуудын тухай дурьдсан анхны тоо баримтууд юм. Нийслэлд 1925 онд 61,000 хүн оршин сууж байснаас 35,000 орчим нь Монголчууд үлдсэн нь хятадууд, оросууд бусад улс орны харьяатууд байжээ. 1926 онд анхны боловсон хоолны газрууд, дэн буудлууд байгуулагдаж байхад 2350 орчим хүнд нэг гуанз, 3000 орчим хүнд нэг дэн буудал ноогддог байжээ.

1935 оноос Улаанбаатар хотыг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөг боловсруулах ажил эхэлсэн бөгөөд 1937 онд Улаанбаатар хотод баригдах барилгын ерөнхий зураг төлөвлөгөөг Худалдаа үйлдвэрийн яамны инженерийн ангиар гүйцэтгүүлэхдээ 12 асуудлыг анхаарахыг үүрэг болгосоны нэгэн зочид буудал байгуулах ажлыг даалгасан байв. Энэ далгаварын дагуу 1938 оны 3-р сарын 1-нд Улаанбаатар хотын байгуулалтыг тэгшитгэн сайжруулах тухай төлөвлөгөө, зураг төслийг танилцуулсан бөгөөд 1938 оны 04-р сарын 1-нд СнЗ-өөс уг зураг төслийг баталжээ. Уг төлөвлөгөө батлагдснаар зочлох үйлчилгээний байгууллагууд шинэ шатанд гарч хөгжих боломж нэгдсэн юм. 1938 оны 9-р сард Хотын намын хорооны тэргүүлэгчдийн хуралд хотын дарга Д.Гомбожав Нийслэл хотын байдлыг сайжруулах талаар тавьсан илтгэлдээ “цаашид үйлчилгээний мэргэжилтэй ажилчдыг бэлдэх хэрэгтэйг онцолжээ. Үйлчилгээний мэргэжилтэй ажилчдыг бэлтгэхэд онцгой анхаарч богино хугацааны курсуудыг явуулж эхэлжээ. 1930 оноос нийслэлээс төдий л хол биш Жанчивлангийн рашааныг ашиглах эхлэлтийг тавьсан бөгөөд 1931 онд Санзайн аманд 60 ортой амралт, айргийн сувиллын газар, 1934 онд зайсангийн аманд Улаанбаатарын рашааныг түшигжүүлж 60 ортой сувиллын газарыг тус тус байгуулжээ. Ингэснээр бусад улс орнуудын жишгээр зочлох үйлчилгээний салбарууд хөгжиж эхэлсэн байна. 1926-1936 оны хооронд хотын захиргаанаас албан ба энгийн хүмүүсийн байгуулсан хоолны гуанзыг олшруулж, хатуу тогтмол үнэ тогтоох, ялангуяа монголчуудын байгуулах хоолны гуанзыг олшруулан гаргахад орон байшингаар туслах зэрэг ажлыг хийж эхэлжээ. 1934 оноос хотын доторх хувийн яргачин, үсчин, ногоочин, гуанзчин, тээвэрчдийг энгийн хэлбэрээр хоршоолол эвлэлдүүлэн зохион байгуулж боловсон үйлчилгээтэй болгох ажлыг хотын захиргаанаас явуулжээ.

1920 оны үеэс Хүрээнд кино үзүүлдэг газрууд бий болж эхэлжээ. 1920-оод оны үед Дайчин бэйсийн хорооны Сономын пүүсийн гудамжны эхэнд автономитын үед баригдсан хөх тоосгон байшинд дуугүй кино гарч орой бүр чийдэн гэрэлтдэг байжээ. Одоогийн Барилгачдын талбайн зүүн урд талд байдаг Христийн сүм байрладаг байшинд 1931 оноос “Ард” нэртэй кинотеатр байгуулагдаж, 1934 онд шинэ байранд буюу одоогийн Ард кинотеатрын байранд нүүж оржээ. “Ард” кино театрт 1937 оноос дуутай кино гаргаж эхэлжээ. Мөн 1930 оноос эхлэн радио нэвтрүүлэг явах болсон байна. Энэ үеэс үйлчилгээний бусад газрууд нээгдэж эхэлсэн байна.

1940-1949 онд хооронд “хотыг сайжруулах” 10 жилийн хугацаатай тойм төлөвлөгөөр хоолны газар бүхий зочид буудлыг барихаар төлөвлөсөн ч Эх орны дайны улмаас эдгээр ажлууд хийгдээгүй байна. Дайны дараа Улаанбаатар хотод энх цагийн бүтээн байгуулалтыг өргөн хүрээг хамруулан явуулж эхэлсэн бөгөөд 1946 оны 8-р сарын 2-нд СнЗ-ийн 47-р хуралданаар “нийслэл Улаанбаатар хотын цаашдын хөгжлийн төлөвлөгөөг батлах” тухай асуудлыг авч хэлэлцээд Улаанбаатар хотын төв хэсэг буюу одоогийн Чингисийн талбай орчмын барилгуудын төлөвлөж томоохон барилгуудыг барьж эхэлсэн байна. Энэ урьдчилсан төлөвлөгөөний дагуу анхны 170 ортой “Алтай зочид буудлын суурийг 1946 онд тавьж, 1948 оны 7-р сарын 7-нд ашиглалтанд оруулжээ. Энэ нь Монголын анхны зочид буудлын зориулалтаар баригдсан зочид буудал бөгөөд ЗХУ-ын

⁸ С.Идшинноров, “Улаанбаатар хотын түүхийн хураангуй,” УБ, 1994 он. Хууд-85.

архитекторын зураг төслөөр Улсын барилга трестийн барилгачид барьжээ. Нийтдээ 19000 м.кв багтаамжтай 60 гаруй өрөө тасалгаа, 170 ор бүхий, зүймэл царсан шалтай тухайн үеийн хамгийн тансаг зочид буудал байв. Энэ барилгад өдгөө Нийслэлийн Засаг даргын тамгын газар байрлаж байна. 1948 онд одоогийн Барилгачдын талбайн баруун талд “Туул” рестораны барилга баригдсан ба энэ нь Улаанбаатар хотын рестораны зориулалтаар баригдсан анхны барилга юм. 1961 онд 20-25 жилийн хугацаатай хэрэгжих Улаанбаатар хотыг хөгжүүлэх 2 ерөнхий төлөвлөгөөг баталсан бөгөөд уг төлөвлөгөө нь өмнөх төлөвлөгөөнөөс ялгагдах онцлог нь орон сууцны барилгыг барихдаа өөртөө соёл, ахуй, худалдаа, нийтийн хоолны зэрэг бүх талын үйлчилгээг бүхий 19 хороололтой байхаар төлөвлөсөн нь ирээдүйн хүн амын тоонд хувиарлаж үйлчилгээний байгууллагуудыг төлөвлөх ажлын эхлэл болсон юм. Энэ төлөвлөгөөний дагуу 1969 оноос эхэлж Зөвлөлт-Монголын барилгачид үйлчилгээний төвтэй хотын олон орон сууцнууд барьж ашиглалтанд оруулжээ. 1976 онд батлагдсан Улаанбаатар хотын хөгжүүлэх 3 төлөвлөгөө дагуу Яармаг, Нисэх, Хайлааст, Чингэлтэй, Баянхошуу, Баруун наран, Партизан зэрэг газруудад сургууль цэцэрлэг, ахуй үйлчилгээний цэгээс гадна 27 нийтийн хоолны газрыг барьж байгуулжээ. 1961 онд Монгол архитекторуудын гараар бүтсэн гайхалтай дизайн шийдэлтэй “Улаанбаатар” зочид буудал баригдаж зочид буудлын салбарт шинэ хуудас нээсэн юм. 1964 онд Баянгол зочид буудал нээгдсэн нь Улаанбаатар зочид буудлын дараа орох хоёр дахь том зочид буудал болжээ. Энэ үед бас гадаадын жуулчидад үйлчлэх мэрэгшсэн жолооч нартай тусгай авто тээврийн бааз байгуулж, жуулчдыг тээвэрлэх аюулгүй байдалд их анхаарч байв.

ХҮСНЭГТ 1. УЛААНБААТАР ХОТЫН ЗОЧЛОХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГУУДЫН ТОО


Он	1926-1940	1941-1950	1951-1960	1961-1970	1971-1980	1981-1990
Зочид буудал, дэн буудлын тоо	2	3	3	5	5	
Рашаан сувиллын газар	3	3	-			8
Нийтийн хоолны газар	50					200
Амралтын газар	0	1	4			16

ЗОЧЛОХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРЫН ХӨГЖЛИЙН ШИНЭ ҮЕ /1991 ОНООС ХОЙШ/

Ардчилсан хувьсгалын дараа буюу 1991 оноос улсын мэдэлд байсан нийтийн хоолны газар, зочид буудал, жуулчны бааз, амралтын газрууд бүгд хувьчлагдаж эхэлсэн байна. Хувьчлалын эхэн үед ихэнх нь хаалга барьж байсан ч хувийн хэвшлийн шинэ үйлчилгээний газрууд бас нээгдэж байв. Анх 1991 онд Засгийн газрын өмч хувьчлалаар Баянгол, Улаанбаатар зочид буудлууд хувьчлагдаж, үүний дараагаар олон амралт, рашаан сувиллын газар, нийтийн хоолны газрууд хувьчлагдаж эхэлсэн байна. Энэ үеэс зочлох үйлчилгээний салбарт шинэ үе эхэлж эрчимтэй хөгжиж эхэлжээ. Тухалбал: өмнө ганц нь хоёр байсан жуулчны бааз 1991 оноос хойш хурдан өсч 2001 онд 22, 2013 онд 390-д хүрсэн ба 20 жилийн дотор 100 дахин өссөн байна. Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт жуулчны баазуудын тоо маш хурдацтай өссөн нь Горхи-Тэрэлжийг улсын тусгай хамгаалалтанд авсантай холбоотой. 1994 онд Горхи-Тэрэлжийн бүсийг хамгаалалтанд авснаар энэ бүсэд жуулчны бааз, амралтын газрууд ихээр байгуулагдаж эхэлжээ. Одоо Улаанбаатар хотын нийт амралтын газар, жуулчны баазуудын 80% нь тус бүсэд төвлөрсөн байна.

1991 оноос мөн адил хооллох үйлчилгээний газрууд хамгийн хурдацтай хөгжиж эхэлсэн байна. Өмнө нь хэдхэн ресторан, 200 хүрэхгүй нийтийн хоолны газрууд байдаг байсан бол үйлчилгээ, хэлбэр нь төрөлжиж ресторан, зоогийн газар, кафе, паб, энгийн гуанз, цайны газрууд хэдэн зуугаараа бий болж үйлчилгээгээ, үнээрээ өрсөлдөж эхэлсэн байна.

ГРАФИК 1. УЛААНБААТАР ХОТЫН ХООЛНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРУУДЫН ТООН ӨСӨЛТ



Эх сурвалж: Нийслэлийн Статистикийн газар⁹

Бусад зочлох үйлчилгээний газруудын адил зочид буудлын салбарт 1991 оноос хойш хурдастай хөгжиж эхэлжээ. 1990 оноос өмнө 4-хөн байсан зочид буудлын тоо, 1997 он гэхэд 300-д хүрч, хүчин чадал, ажиллагсдын тоо, ор хоногийн тоо 15-20 дахин нэмэгдсэн байна. Зочид буудлын тоон өсөлтийг графикаар харуулбал

ГРАФИК 2. ЗОЧИД БУУДАЛ, ДЭН БУУДАЛ ТООН ӨСӨЛТ




Эх сурвалж: Нийслэлийн Статистикийн газар(200-2012), Нийслэлийн Аялал жуулчлалын газар(2013 он)¹⁰

1997 оноос 2007 онд зочид буудал, дэн буудлыг хамт тоолж статистик судалгааг гаргаж ирсэн байна. Зочид буудал, дэн буудлын тоо өсөх тусам тус салбарын орлого нэмэгдэж Нийслэлийн хотын үйлчилгээний гол салбар болж эхэлсэн байна.

⁹ -“Нийслэлийн нийгэм, эдийн засаг – 2003 он” танилцуулгын хавсралт, Нийслэлийн Статистикийн газар, 2014 он

¹⁰ - Нийслэлийн Статистикийн газрын 2003-2012 оны статистик мэдээлэл, Нийслэлийн Аялал жуулчлалын газрын 2013 оны тоо баримт

ГРАФИК 3. НИЙСЛЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРЫН БОЛОН ЗОЧИД БУУДЛЫН САЛБАРЫН НИЙТ ОРЛОГЫН ХАРЬЦАА




Эх сурвалж: “Нийслэлийн нийгэм, эдийн засаг – 2003 он” танилцуулгын хавсралт

1994 онд зочид буудлын салбар Улаанбаатар хотын үйлчилгээний салбарын нийт орлогын 26,8%-ийг бүрдүүлж байсан бол 2003 онд үйлчилгээний салбарын нийт орлогын 49,47%-ийг буюу тэн хагасыг бүрдүүлдэг болжээ. Өнөөдөр ч гэсэн зочид буудал салбар Улаанбаатар хотод бусад үйлчилгээний байгууллагуудаас хамгийн олон нь бөгөөд үйлчилгээний салбарын нийт орлогын 50 орчим хувийг бүрдүүлж байна.

2007 оноос дэн буудлын стандартыг шинэчилж MNS 4738;2007 стандарт, 2008 онд зочид буудлын стандартыг шинэчилж MNS 4588;2008 стандартыг тус тус баталсан ба 2008 оноос хойш зочид буудал, дэн буудлын тоог тус тусдаа гаргаж эхэлсэн байна.

ГРАФИК 4. ЗОЧИД БУУДАЛ, ДЭН БУУДЛЫН ХАРЬЦАА



Эх сурвалж: Нийслэлийн Аялал жуулчлалын газар¹¹

Зочлох үйлчилгээний салбарын бусад байгууллагуудтай холбоотой судалгаа сайн хийгдээгүй байна. Жишээлбэл караоке, сувиллын газар, амралтын газар, жуулчны баазуудын талаарх хангалттай судалгааны тоо баримтууд байхгүй байна. Тиймээс олдсон тоо баримтуудыг хүснэгтэлж орууллаа.

¹¹ Нийслэлийн Аялал жуулчлалын газрын 2013 оны тоо баримт

ХҮСНЭГТ 2.ЗОЧЛОХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГУУДЫН ТООН ӨСӨЛТ

Он Төрөл	1992	1993	1994	1995	1996	1997	1998	1999	2000	2001	2002	2003	2004	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013
Жуулчны бааз										22		17			180					390		
Амралтын газар										4		20										
Рашаан сувиллын газар									2	2	2	3	2	2	2	2	2					
Ресторан, зогийн газар	23	41	65	87	138	173	191	242	262	262	199	239	277	450								
Зочид буудал						301	315	262	273	326	432	364			320			229	200	207	162	206
Дэн буудал																		263	249	220	300	249
Баар	18	46	79	100	135	395	449	511	585	561	557	514	464	635								
Цайны газар, кафе, гуанз					692	701	933	1192	1474	1513	1098	1428	1440	1438								

Эх сурвалж: Нийслэлийн 2000-2010 оны статистикийн эмхэтгэл¹²

Өнөөдөр Улаанбаатар хот /2012 он байдлаар/ Монгол улсын дотоодын нийт бүтээгдэхүүний 64 хувийг бүрдүүлдэг ба эдийн засаг нь 8,967.8 тэрбум төгрөгт хүрсэн байна. Нийслэлийн эдийн засгийн 68,8 хувийг үйлчилгээний салбар эзэлж байна[3;37]. Үйлчилгээний салбар дотроос хамгийн их хувийг эзэлдэг нь зочлох үйлчилгээний салбар ба тэн хагасыг нь эзэлж байна.

¹² Нийслэлийн 2000-2010 оны хоорондох бүх статистикийн тоо баримтаас түүж оруулав.

№	Овог нэр	Албан	Албан тушаал	Цахим хуудас	Утасны дугаар 1	Утасны дугаар 2	Өгүүллэ гийн нэр /Монгол /	Өгүүллэгийн нэр /Англи/	Abstract	Хураангуй	Цээж зураг
1	Баделгажы Ербахыг	Нийслэлийн	Хот орчмын аялал жуулчлал хариуцсан	Erbahit_10@yahoo.com	99413120	70128687	Улаанба атар хотын зочлох үйлчилг ээний салбары н үүсэл хөгжил	The origin and development of hospitality service sector of Ulaanbaatar city.	The service sector was founded and developed in 1639 in Ulaanbaatar, and the time divided into four phases of development. The first hospitality service was founded at the beginning of 20 th century by serving Bogd Khaan's honorary guests. Nowadays the service sector becoming the urgent sector of Ulaanbaatar city and the main sector of service sector is hospitality.	Улаанбаатар хотод үйлчилгээний салбар 1639 оноос үүсэж хөгжсөн бөгөөд хөгжлийн хугацааг дөрвөн үе шатад хуваан үзэж болно. Анхны “үйлчилгээ” Богд Гэгээнтэн болон түүний хүндэт зочдод монгол айл гэрийн зочломтгой жаягаар үйлчлэхээс эхэлжээ. Өнөөдөр үйлчилгээний салбар Улаанбаатар хотын гол салбар болсон бөгөөд үйлчилгээний салбар дотроо зочлох үйлчилгээний салбар нь голлох байр сурийг эзэлж байна.	

Зохиогчийн тухай:

Баделгажы овогтой Ербахыт нь 1991 онд төрсөн. 2013 онд МУБИС-ийг Газарзүй-Аялал жуулчлал мэргэжлээр төгссөн. Газарзүйн ухааны магистрант. Одоо Нийслэлийн Аялал жуулчлалын газарт Хот орчмын аялал жуулчлал хариуцсан мэргэжлтнээр ажилладаг. Зочлох үйлчилгээний байгууллагуудын газарзүйн байршил, Хот орчмын аялал жуулчлал, реакрацийн чиглэлээр судалгаа хийдэг.